

"MONPASS CLIENT" ПРОГРАМ СУУЛГАХ, АШИГЛАХ ЗААВАР

Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага

Боловсруулсан:

"МонПасс СА" ХХК Гэрчилгээ Олгох Байгууллага Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, БЗД, 1 хороо, Токиогийн гудамж, НИСОРА цамхаг 702 тоот Утас: +976 76113286 | Факс: +976 76103286 И-Мэйл: info@monpass.mn | Веб сайт: www.monpass.mn

Зориулалт	Огноо	Хувилбар
Хэрэглэгч	2016.05.02	1.0

АГУУЛГА

1.	"MONPASS CLIENT" ПРОГРАМЫН ТУХАЙ	3
2.	"MONPASS CLIENT" ПРОГРАМЫГ ТАТАЖ, СУУЛГАХ ЗААВАР	. 4
3.	"MONPASS CLIENT" ПРОГРАМЫГ АШИГЛАХ ЗААВАР	6

1. "MONPASS CLIENT" ПРОГРАМЫН ТУХАЙ

Хэрэглэгч Тоон гарын үсгийн гэрчилгээ болон түүний тээгч Э-Токен төхөөрөмжийг ашиглахын тулд дараах бэлтгэлийг хангасан байх шаардлагатай:

- 1. Э-Токен төхөөрөмжийн драйверийг суулгах;
- 2. Монголын үндэсний Суурь гэрчилгээжүүлэх байгууллагын суурь гэрчилгээ болон "МонПасс СА" Гэрчилгээ олгох байгууллага (ГОБ)-ын гэрчилгээг Итгэгдсэн гэрчилгээний сан (Microsoft Trusted Certificate Store)-д суулгах шаардлагатай болдог.

"Monpass Client" програмыг суулгах явцад дээрх 2 ажиллагаа нэгэн зэрэг автоматаар гүйцэтгэгдэнэ. "Monpass Client" програм нь дараах зориулалтаар ашиглагдана:

- 1. Э-Токен төхөөрөмжийг удирдах:
 - ГОБ-аас Тоон гарын үсгийн гэрчилгээг олгосны дараа Э-Токен төхөөрөмжид гэрчилгээг татаж суулгах;
 - Э-Токен төхөөрөмжийн PIN код (нууц үг)-ыг солих;
- 2. Word, Excel, PDF форматтай баримт бичигт тоон гарын үсэг зурах;
- 3. Тоон гарын үсгээр баталгаажсан баримтын гарын үсэг эзэмшигчийн мэдээллийг шалгаж, харуулах;

2. "MONPASS CLIENT" ПРОГРАМЫГ ТАТАЖ, СУУЛГАХ ЗААВАР

- 1. <u>www.monpass.mn</u> сайтад нэвтэрч, "Хэрэглэгчийн хөтөч" цэсийг сонгоно.
- 2. "Хэрэглэгчийн хөтөч цэсээс "Э-Токен драйвер /Windows x32-x64/ татах" линк дээр дарж, програмыг татаж авна.
- 3. Татаж авсан .exe файл дээр 2 удаа дарж (Double Click), програмыг суулгах ажиллагааг эхлүүлнэ.
- 4. 1 Install дарна, 2 Yes дарна, 3 үйлдэл хийхгүйгээр хүлээнэ.



5. 4 - Safenet Authentication Client драйверийг суулгах цонх нээгдэхэд Next, 5 - Next, 6 - I accept the license agreement сонгоод, Next дарна.



6. 7 - Standard сонгоод Next, 8 - Next, 9 - үйлдэл хийхгүйгээр хүлээнэ.



7. 10 - Cancel, 11 – үйлдэл хийхгүйгээр хүлээнэ, 12 – Finish дарсанаар MonPass Client програмыг суулгах ажиллагаа амжилттай дуусна.

😸 Installer Information 🛛 🕹 🗙	😸 SafeNet Authentication Client 8	3.0 SP2 Setup — 🗆 🗙	😸 SafeNet Authentication Clier	nt 8.0 SP2 Setup — 🗆 🗙
SafeNet Authentication Client installer will update your Mozilla Firefox browser. Please close your Mozilla Firefox browser, wait few seconds, and press Ok. Press Cancel to skip update.	Installing Safenet drivers iKey Driver	Updating System The selected features are being installed. : (Sustem)	SafeNet Authentication Client	SafeNet Authentication Client 8.0 SP2 has been successfully
<u>D</u> K <u>C</u> ancel	Creating SmartCa	rd readers. Please Wait	SafeNet .	installed. Click Finish to exit Setup.
	11	Cancel	12	< Back Finish Cancel

3. "MONPASS CLIENT" ПРОГРАМЫГ АШИГЛАХ ЗААВАР

1. "Monpass Client" програмыг нээнэ.



Зураг 1. "Monpass Client" програмын үндсэн цонх

2. "Шинэ тоон гарын үсэг суулгах" цэс. ГОБ-аас Э-Токен эзэмшигчид Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсоны дараа "Шинэ тоон гарын үсэг суулгах" цэсийн "Хүлээгдэж байгаа тоон гарын үсэг" жагсаалтад гэрчилгээний мэдээлэл орж ирнэ. Ийнхүү гэрчилгээний мэдээлэл харагдаж байвал "Суулгах" товч дээр дарж гэрчилгээг Э-Токенд суулгана.



Зураг 2. Шинэ тоон гарын үсгийн гэрчилгээ суулгах

3. **"Миний тоон гарын үсгүүд" цэс**. Энэ цэсрүү ороход хэрэглэгчийн Э-Токен төхөөрөмжид бичигдсэн Тоон гарын үсгийн гэрчилгээний жасгаалтыг харуулна. Жагсаалтаас гэрчилгээг сонгоод, цонхны зүүн хэсэгт байрлах "Зураг солих" товч дээр дарж, Тоон гарын үсэг зурах файлд харагдах зургийг өөрчилж, өөрийн гарын үсэг болон тамганы зургаар сольж болно (*Зураг 4*).

Миний тоон гарын үсэг				×	Þ	Линий тоон гарын үсэг					×
MonPass Client	4	Open (v 👌 🛛 Seerch Pictu	× ** * •		MonPass Client	Мини	ий тоон гарын үсэ	F		
Тоон гарын үслийн сертификат уйирдах, хархааг жилдэршураа зорилгоор Монласс СА XXX-наас Болоксрумаа	Гэрмлгээний	A Doubles of a constant of the constant o	Saved Pictures 35	Screenshots		Тоон гарын үсийн сөртөфинат уйндэх, нэрэгжэу халбариунан зорилгоор Монтасс СА XXX-наас Болоксрумаа.	Гэрмлгээний нэр	Байгуулгагын нэр	Албан тушаал	Дусях отноо	Серийн дугаар
		3 Beeage 3 Second the 3 Second the 3 Second the 3 Second the 3 Second the 5 Sec				Almy-					
3jpar conix All rights reserved. Copyright 2016			Upen	Буцах		3yper control All rights reserved, Copyright 2016	-				Буцах

Зураг З. Зураг солих

Зураг 4. Зураг солигдсоны дараа

4. **"PIN код солих" цэс.** Энэ цэсийн тусламжтайгаар хэрэглэгч Э-Токен төхөөрөмжид хандах **PIN код** буюу өөрийн нууц үгээ солино. Хэрэглэгч нууцлалын аюулгүй байдлыг хангах үүднээс PIN кодоо том, жижиг үсэг, цифр оруулсан 6, түүнээс дээш тэмдэгт ашиглавал зохино.



- 5. Баримт бичигт тоон гарын үсэг зурж баталгаажуулах. Баримт бичигт тоон гарын үсэг зурахдаа:
 - "Гарын үсэг зурах" хэсгээс гарын үсэг зурахыг хүссэн файлын форматыг сонгоно.



Зураг 6. Баримт бичигт тоон гарын үсэг зурах

• Гарын үсэг зурах файлыг нээнэ.

The second second	******		<pre>0.0</pre>		
Opm			×	a	
← → ★ ↓ > This	PC > Downloads v Pr	Search Desceloarie	Ø		
		- The -			Баталгаажу
Organize • New folder		Brt •	U U		
A Quick access	Name	Date modified	Type ^		
👃 Downloads 🚿	d7t8XOFfw.pdf	16.02.29 14:25	Adobe Ar		
Desktop 🖈	document(1).pdf	16.02.02 9:57	Adobe Ar		
G OneDrive d	document(2).pdf	16.03.15 10:13	Adobe A		
Decoments of	document(3).pdf	16.03.15-11:27	Adobe A		
Distance of	document.pdf	16.02.02 9:57	Adobe Ar		
Proures /	 merzowne.per 	10/02/02 9/20	ABODE AL		
c, seree	 organization_official_lattar.form.ndf 	16 04 05 0 34	Adobe Ar		
hewich	Signature-Encryption-Banks-Editable od	16.02.08 10.16	Adobe A		
Odbayar	T/A4hi8c.pdf	16.02.08 15:53	Adobe A		
ГАРЫН АВЛАГА	5 t9u78M6DR.pdf	16.03.15 10:32	Adobe Ar		
ConeDrive	V5r8dlk5m.pdf	16.02.01 16:00	Adobe Ar		
-	🔁 v6W04UCRI.pdf	16.02.01 17:44	Adobe Ar	1	
This PC	🕏 w7v0gH73h.pdf	16.02.02 19:41	Adobe Ar ¥		
File pan	d7t8XOFfw.pdf ~	PDF Documents *.pdf	~		

Зураг 7. Баримт бичигт тоон гарын үсэг зурах

 Дэлгэцийн баруун дээд хэсэгт байрлах "Баталгаажуулах" товчийг дарж, баримтад гарын үсэг байрлуулахыг хүссэн талбарыг хулганаар сонгон дарна. "Хадгалах" цонх нээгдэхэд тоон гарын үсэг зурагдсаны дараа файлыг хадгалах замыг зааж, шинэ нэрээр хадгалах бол "File name" талбарт шинэ нэрийг бичиж, "Save" дарна.



Зураг 8. Тоон гарын үсэг зурагдсанбаримтад шинэ нэр өгч хадгалах

• Э-Токен төхөөрөмжид хадгалагдаж буй Тоон Гарын үсгийн гэрчилгээнүүдийн жагсаалт бүхий цонх нээгдэхэд зохих гэрчилгээг сонгон "Батлах"

товч дарна.

	Гэрчилгээний нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Дуусах огноо	Серийн дугаар
удирдак, хэрэглээг кялбаршуулах	баасансурэн ганхуяг	МонПасс СА, олголт		2017/03/31	18579595000000000
Боловсруглав.	баяр болд	Туршилт хох, захир		2017/04/07	145D9E 190000000004

Зураг 9. Тоон гарын үсгийн гэрчилгээг сонгох

• Э-Токен төхөөрөмжийн РІN кодыг оруулж "Нэвтрэх" товч дарна.



Зураг 10. Э-Токен төхөөрөмжийн PIN кодыг оруулах

• Баримт бичигт тоон гарын үсэг зурагдаж, баталгаажсаны дараа "Амжилттай" гэсэн мэдээг харуулна.



Зураг 11. Тоон гарын үсэг амжилттай зурагдсан байдал